



2022 оны 03 дугаар сарын 25
№12 /1210/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦᠰᠡᠭᠦᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠶᠦᠰᠢᠨᠲᠦᠭᠦᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠶᠦᠰᠢᠨᠲᠦᠭᠦᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ





МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

ПРОТОКОЛД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Кигали хотноо 2016 онд хуралдсан 28 дугаар хуралдаанаас “Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протокол”-д оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

Үсэнтэй бичиг /м/

Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000

Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000
Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000

6 км-ын хэмжээг .. илүүтэйгээр 2000 Ө мөн /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000
Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000
Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000
Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000

Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000
Үсэнтэй бичиг /м/ 76 - Ө мөн 60 Ө мөн 7000



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 01 дүгээр
сарын 18-ны өдөр

Дугаар 08

Улаанбаатар
хот

Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Ашигт малтмалын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

2/Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон бусад татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон зарим татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл;

3/Газрын багц хуулийн төсөл;

4/Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5/Дампуурлын тухай хуулийн төсөл буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

6/Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7/Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8/Зарим төрлийн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг түр зогсоох тухай анхдагч хуулийн төсөл;

9/Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10/Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;



11/Зөрчлийн тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;
12/Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13/Иргэний болон захиргааны шүүхийн шийдвэр гүйцэтгэх
тухай анхдагч хуулийн төсөл;

14/Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн
төсөл /Шинэчилсэн найруулга/;

15/Иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний
тухай хуулийн төсөл;

16/Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн төсөл;
18/Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2023 оны төсвийн
хүрээний мэдэгдэл, 2024-2025 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн
төсөл;

20/Монгол Улсын 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл,
Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2021 оны
төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

21/Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах
тухай хуулийн төсөл;

22/Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

23/Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт
орлуулах тухай хуулийн төсөл;

24/Өндөр насны тэтгэврийн доод хэмжээг нэмэгдүүлэх
тухай хуулийн төсөл;

25/Төрийн өмчийн тухай хуулийн төсөл;
26/Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай
анхдагч хуулийн төсөл;



27/Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл;
28/Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн төсөл;

29/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн тухай хуулийн төсөл;

30/Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

31/Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

32/Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

33/Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

34/Төрийн жинхэнэ албаны сонгон шалгаруулалтын тусгай журмын тухай хуулийн төсөл;

35/Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл;
36/Тээврийн нэгдсэн хуулийн анхдагч хуулийн төсөл;
37/Тэтгэврийн доод хэмжээг индексжүүлэх тухай хуулийн төсөл;

38/Улс төрийн намын тухай хуулийн төсөл;
39/Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

40/Үндэсний баялгийн сангийн тухай анхдагч хуулийн төсөл;

41/Үндэсний их баяр наадмын тухай хуулийн төсөл;
42/Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

43/Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл;
44/Хог хаягдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

45/Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

46/Хөгжлийн сангийн тухай анхдагч хуулийн төсөл;



47/Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

48/Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

49/Шилэн дансны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

50/Шүүх байгуулах тухай хуулийн төсөл;

51/Шүүхийн шинжилгээний тухай хуулийн төсөл /Шинэчилсэн найруулга/;

52/Шүүхийн бус журмаар өр барагдуулах тухай анхдагч хуулийн төсөл;

53/Эдийн засгийн сэргэлтийг дэмжих хөгжлийн төслийг санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх тухай анхдагч хуулийн төсөл.

2.“Ковид-19” цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг тухай бүр хэлэлцсүгэй.

3.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэрлэж байхаар тогтоосугай.

4.Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлгүүд, Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГ БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛИЙН ПРОТОКОЛД ОРУУЛАХ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Шийдвэр ХХVIII/1: Монреалийн Протоколд оруулах нэмэлт, өөрчлөлт

Оролцогч улсуудын 28 дугаар бага хурлын тайлангийн хавсралт I-т тусгасан Монреалийн Протоколд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Озоны үе давхаргыг хамгаалах тухай Венийн Конвенцийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан журмын дагуу батлах;

Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколд оруулах нэмэлт, өөрчлөлт

I зүйл: Нэмэлт, өөрчлөлт

1 дүгээр зүйл, 4 дэх хэсэг

Протоколын 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт дараах үгсийг:

“Хавсралт С, эсхүл Хавсралт Е”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“Хавсралт С, Хавсралт Е, эсхүл Хавсралт F”

2 дугаар зүйл, 5 дахь хэсэг

Протоколын 2 дугаар зүйлийн 5 дугаар заалтын:

“болон 2H дугаар зүйл”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2H ба 2J дугаар зүйлүүд”

2 дугаар зүйл, 8 (а), 9 (а) болон 11 дүгээр заалтууд

Протоколын 2 дугаар зүйлийн 8 (а) ба 11 дүгээр заалтуудын:

“2A-аас 2I дугаар зүйлүүд”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2A-аас 2J дугаар зүйлүүд”

Протоколын 2 дугаар зүйлийн 8 дугаар заалтын (а) дугаар дэд заалтын төгсгөлд дараах үгсийг нэмж оруулна:

“Талуудын авч үзэж буй хэрэглээ, эсхүл үйлдвэрлэлийн нийт нэгтгэн тооцсон түвшин 2J дугаар зүйлийн дагуу шаардагдах түвшнээс хэтрээгүй тохиолдолд 2J дугаар зүйлийн хүрээнд хэрэглээ, эсхүл үйлдвэрлэлтэй хамааралтай үүргийг багтаахын тулд ийм төрлийн гэрээг өргөжүүлж болно.”



Протоколын 2 дугаар зүйлийн 9 дүгээр заалтын (а) (i) дугаар дэд заалтад: “байж болно,”

гэсэн үгсийг хоёр удаа ашигласны дараа:

“ба” гэсэн үгийг устгана.

Протоколын 2 дугаар зүйлийн 9 дүгээр заалтын (а) (ii) дугаар дэд заалтыг (а) (iii) дугаар дэд заалт гэж дахин дугаарлана.

Протоколын 2 дугаар зүйлийн 9 дүгээр заалтын (а) (i) дугаар дэд заалтын дараа (а) (ii) дугаар дэд заалт гэсэн хэсэгт дараах үгсийг нэмж оруулна:

“Хавсралт А, Хавсралт С болон Хавсралт F–ийн I бүлэгт тодорхойлсон дэлхийн дулааралд нөлөөлөх чадавх тохиргоо залруулга хийх бөгөөд тийм тохиолдолд тэдгээр тохиргоо залруулга ямар байх; ба”

2J дугаар зүйл

Протоколын 2I дугаар зүйлийн дараа дараах зүйлийг нэмж оруулна:

“2J дугаар зүйл: Гидрофторт нүүрстөрөгчүүд

1. Оролцогч улс тус бүр нь 2019 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд, мөн түүнээс хойш 12 сар тутамд тэдгээрийн Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисын CO₂-т шилжүүлэн тооцсон хэрэглээний түвшин нь дор дурдсан (а)–аас (е) хүртэлх дэд заалтад жилээр ангилан харуулсан 2011, 2012, 2013 онуудад тооцсон Хавсралт F–ийн зохицуулагдах бодисын хэрэглээний тооцсон түвшний жилийн дундаж хувиас хэтрэхгүй байх, түүн дээр нэмээд 2F дүгээр зүйлийн 1 дүгээр заалтад тодорхойлсон Хавсралт C–ийн I бүлгийн зохицуулагдах бодисын CO₂-т шилжүүлэн тооцсон хэрэглээний түвшний 15 хувиас хэтрэхгүй байх нөхцөлийг хангана:

(a) 2019 – 2023: 90 хувь

(b) 2024 – 2028: 60 хувь

(c) 2029 – 2033: 30 хувь

(d) 2034 – 2035: 20 хувь

(e) 2036 он ба түүнээс хойш: 15 хувь

2. Энэ зүйлийн 1 дүгээр заалтыг үл харгалзан Оролцогч улс нь 2020 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд, мөн түүнээс хойш 12 сар тутамд түүний Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисын CO₂-т шилжүүлэн тооцсон хэрэглээний түвшин нь дор дурдсан (а)–аас (е) хүртэлх дэд заалтад жилээр ангилан харуулсан 2011, 2012, 2013 онуудад тооцсон Хавсралт F–ийн зохицуулагдах бодисын хэрэглээний тооцсон

түвшний жилийн дундаж хувиас хэтрэхгүй байх, түүн дээр нэмээд 2F дүгээр зүйлийн 1 дүгээр заалтад тодорхойлсон Хавсралт С–ийн I бүлгийн зохицуулагдах бодисын CO₂–т шилжүүлэн тооцсон хэрэглээний түвшний 25 хувиас хэтрэхгүй байх нөхцөлийг хангана хэмээн Талууд шийдвэрлэж болно:

- (a) 2020 – 2024: 95 хувь
- (b) 2025 – 2028: 65 хувь
- (c) 2029 – 2033: 30 хувь
- (d) 2034 – 2035: 20 хувь
- (e) 2036 он ба түүнээс хойш: 15 хувь

3. Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисыг үйлдвэрлэгч Оролцогч улс тус бүр нь 2019 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд, мөн түүнээс хойш 12 сар тутамд тэдгээрийн Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисын CO₂–т шилжүүлэн тооцсон үйлдвэрлэлийн түвшин нь дор дурдсан (a)–аас (e) хүртэлх дэд заалтад жилээр ангилан харуулсан 2011, 2012, 2013 онуудад тооцсон Хавсралт F–ийн зохицуулагдах бодисын үйлдвэрлэлийн тооцсон түвшний жилийн дундаж хувиас хэтрэхгүй байх, түүн дээр нэмээд 2F дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлсон Хавсралт С–ийн I бүлгийн зохицуулагдах бодисын CO₂–т шилжүүлэн тооцсон үйлдвэрлэлийн түвшний 15 хувиас хэтрэхгүй байх нөхцөлийг хангана:

- (a) 2019 – 2023: 90 хувь
- (b) 2024 – 2028: 60 хувь
- (c) 2029 – 2033: 30 хувь
- (d) 2034 – 2035: 20 хувь
- (e) 2036 он ба түүнээс хойш: 15 хувь

4. Энэ зүйлийн 3 дугаар заалтыг үл харгалзан Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисыг үйлдвэрлэгч аль нэг Оролцогч улс нь 2020 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд, мөн түүнээс хойш 12 сар тутамд түүний Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисын CO₂–т шилжүүлэн тооцсон үйлдвэрлэлийн түвшин нь дор дурдсан (a)–аас (e) хүртэлх дэд заалтад жилээр ангилан харуулсан 2011, 2012, 2013 онуудад тооцсон Хавсралт F–ийн зохицуулагдах бодисын үйлдвэрлэлийн тооцсон түвшний жилийн дундаж хувиас хэтрэхгүй байх, түүн дээр нэмээд 2F дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлсон Хавсралт С–ийн I бүлгийн зохицуулагдах бодисын CO₂–т шилжүүлэн тооцсон үйлдвэрлэлийн түвшний 25 хувиас хэтрэхгүй байх нөхцөлийг хангана хэмээн Талууд шийдвэрлэж болно:

- (a) 2020 – 2024: 95 хувь
- (b) 2025 – 2028: 65 хувь



- (c) 2029 – 2033: 30 хувь
- (d) 2034 – 2035: 20 хувь
- (e) 2036 он ба түүнээс хойш: 15 хувь

5. Энэ зүйлийн 1–ээс 4 дүгээр заалтууд нь Оролцогч талуудын тохирсны дагуу чөлөөлөгдсөн гэх хэрэглээ хангахад хэрэгцээтэй үйлдвэрлэлийн, эсвэл хэрэглээний түвшинг Талууд хүлээн зөвшөөрөх шийдвэр гаргаснаас бусад бүх тохиолдолд үйлчилнэ.

6. Хавсралт С–ийн I бүлэг, эсхүл Хавсралт F–д заасан бодисуудыг үйлдвэрлэдэг Оролцогч улс тус бүр нь 2020 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 12 сарын хугацаанд, мөн түүнээс хойш 12 сар тутамд тэдгээрийн Хавсралт F–ийн II бүлгийн бодисуудын ялгарал, Хавсралт С–ийн I бүлгийн бодисуудыг үйлдвэрлэдэг байгууламж тус бүрийн үйлдвэрлэлийн явцад бий болдог бодисуудыг хамруулна, эсхүл мөн ижил 12 сарын хугацаанд Талуудын хүлээн зөвшөөрсөн технологийг ашиглах явцад Хавсралт F–ийн бодисуудыг бодит хэмжээнд устгана.

7. Хавсралт С–ийн I бүлгийн бодис болон Хавсралт F–ийн бодисууд үйлдвэрлэдэг байгууламжуудын үйлдвэрлэлийн явцад бий болдог Хавсралт F–ийн II бүлгийн аливаа бодисыг Оролцогч улс тус бүр устгахдаа зөвхөн Талуудын хүлээн зөвшөөрсөн технологийг ашиглана.

3 дугаар зүйл

Протоколын 3 дугаар зүйлийн өмнөх үгийг дараах байдлаар өөрчилж солино:

“1. 2, 2A–аас 2J, 5 дугаар зүйлүүдийн хүрээнд Оролцогч улс тус бүр нь Хавсралт А, Хавсралт В, Хавсралт С, Хавсралт Е, эсхүл Хавсралт F–д заасан бодисуудын бүлэг тус бүрийн бодисуудын өөрсдийн тооцсон түвшинг тодорхойлно.”

Протоколын 3 дугаар зүйлийн (a) (i) дугаар дэд заалтын төгсгөлийн цэгтэй таслалтай хэсэгт:

“, 2 дугаар заалтад зааснаас бусад тохиолдлоос гадна;” гэж оруулна.
Протоколын 3 дугаар зүйлийн төгсгөлд дараах бичвэрийг нэмж оруулна:
“; болон

(d) Хавсралт F–ийн II бүлгийн бодисуудын ялгарал, Хавсралт С–ийн I бүлгийн бодисуудыг үйлдвэрлэдэг байгууламж тус бүрийн үйлдвэрлэлийн явцад бий болдог бодисууд, эсхүл Хавсралт F–д заасан бодисууд бөгөөд үүнд бусад зүйлсээс гадна тоног төхөөрөмжөөс гарах алдагдал,

агааржуулах хоолой, задлах төхөөрөмжөөс гарах ялгарлын хэмжээг хамруулах ба ашиглалт, устгал, эсхүл хадгалалтын явцад хураасан хэмжээг хамруулахгүй.

2. Хавсралт F ба Хавсралт C –ийн I бүлэг, 2J дугаар зүйлийн зориултат бодисууд, 2 дугаар зүйлийн 5 *bis* дугаар заалт, 3 дугаар зүйлийн 1 (d) дүгээр заалтад заасан бодисуудын үйлдвэрлэл, хэрэглээ, импорт, экспорт, ялгарлын түвшинг CO₂-т шилжүүлэн тооцохдоо Оролцогч улс тус бүр нь Хавсралт A, Хавсралт C ба Хавсралт F-ийн I бүлэгт заасан тэдгээр бодисуудын дэлхийн дулааралд нөлөөлөх чадавхыг нь ашиглана.”

4 дүгээр зүйл, 1 sept дүгээр заалт

Протоколын 4 дүгээр зүйлийн 1 *sex* дүгээр заалтын дараа дараах заалтыг нэмж оруулна:

“1 *sept*. Энэ заалт хүчин төгөлдөр болсноор Оролцогч улс тус бүр нь Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисуудыг Протоколын Оролцогч биш улсаас импортлохыг хориглоно.”

4 дүгээр зүйл, 2 sept дүгээр заалт

Протоколын 4 дүгээр зүйлийн 2 *sex* дүгээр заалтын дараа дараах заалтыг нэмж оруулна:

“2 *sept*. Энэ заалт хүчин төгөлдөр болсноор Оролцогч улс тус бүр нь Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисуудыг Протоколын Оролцогч биш улсад экспортлохыг хориглоно.”

4 дүгээр зүйл, 5, 6, 7 дугаар заалтууд

Протоколын 4 дүгээр зүйлийн 5, 6, 7 дугаар заалтуудад:

“Хавсралтууд A, B, C, E”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“Хавсралтууд A, B, C, E, F”

4 дүгээр зүйл, 8 дугаар заалт

Протоколын 4 дүгээр зүйлийн 8 дугаар заалтад:

“2A –аас 2I дугаар зүйлүүд”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2A –аас 2J дугаар зүйлүүд”

4В дүгээр зүйл

Протоколын 4В дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дараа дараах заалтыг нэмж оруулна:

“2 bis. 2019 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн, эсхүл энэ заалт хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 3 сарын дотор Оролцогч улс тус бүр нь Хавсралт F–д заасан шинэ, ашигласан, дахин боловсруулсан, сэргээн сайжруулсан зохицуулагдах бодисуудын импорт, экспортод олгох зөвшөөрлийн тогтолцоог бий болгон, хэрэгжүүлнэ. 5 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй аливаа Оролцогч улс тухайн зөвшөөрлийн тогтолцоог 2019 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс бий болгон, хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл тухайн үйл явцыг 2021 оны нэгдүгээр сарын 1-ний өдөр хүртэл хойшлуулах боломжтой.”

5 дугаар зүйл

Протоколын 5 дугаар зүйлийн 4 дүгээр заалтад:

“2I”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2J”

Протоколын 5 дугаар зүйлийн 5, 6 дугаар заалтуудад:

“2I дугаар зүйл”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2I, 2J дугаар зүйлүүд”

Протоколын 5 дугаар зүйлийн 5 дугаар заалтын:

“аливаа зохицуулах арга хэмжээнүүд”

гэсэн үгнүүдийн өмнө:

“хамт” гэсэн үгийг нэмж оруулах

Протоколын 5 дугаар зүйлийн 8 *ter* дугаар заалтын дараа дараах заалтыг нэмж оруулна:

“8 *qua*

(а) 2 дугаар зүйлийн 9 дүгээр заалтад нийцүүлэн 2J дугаар зүйлд заасан хянах арга хэмжээнүүдэд оруулсан аливаа тохиргоо залруулгын нөхцөлд энэ зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Оролцогч улс тус бүр нь 2J дугаар зүйлийн 1 дүгээр заалтын (а)–аас (е) дүгээр дэд заалтууд, 2J дугаар зүйлийн 3 дугаар заалтын (а)–аас (е) дүгээр дэд заалтуудад дурдсан хянах арга хэмжээний биелэлтийг хангах ажлаа хойшлуулах ба тэдгээр арга хэмжээг дараах байдлаар өөрчлөх эрхтэй:

- (i) 2024 – 2028: 100 хувь
- (ii) 2029 – 2034: 90 хувь
- (iii) 2035 – 2039: 70 хувь
- (iv) 2040 – 2044: 50 хувь
- (v) 2045 он ба түүнээс хойш: 20 хувь

(b) Дээр дурдсан (a) дугаар дэд заалтыг үл харгалзан 2 дугаар зүйлийн 9 дүгээр заалтад нийцүүлэн 2J дугаар зүйлд заасан хянах арга хэмжээнүүдэд оруулсан аливаа тохиргоо залруулгын нөхцөлд энэ зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Оролцогч улс нь 2J дугаар зүйлийн 1 дүгээр заалтын (a)-аас (e) дүгээр дэд заалтууд, 2J дугаар зүйлийн 3 дугаар заалтын (a)-аас (e) дүгээр дэд заалтуудад дурдсан хянах арга хэмжээний биелэлтийг хангах ажлаа хойшлуулах ба тэдгээр арга хэмжээг дараах байдлаар өөрчлөх эрхтэй гэж Талууд шийдвэрлэж болно:

- (i) 2028 – 2031: 100 хувь
- (ii) 2032 – 2036: 90 хувь
- (iii) 2037 – 2041: 80 хувь
- (iv) 2042 – 2046: 70 хувь
- (v) 2047 он ба түүнээс хойш: 15 хувь

(c) Энэ зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Оролцогч улс тус бүр нь 2J дугаар зүйлийн хүрээнд өөрийн хэрэглээний суурь түвшинг тооцохдоо 2020, 2021, 2022 онуудаар тооцсон Хавсралт F–ийн хянагдах бодисуудын хэрэглээний тооцсон түвшний дундаж, түүний дээр нэмээд энэ зүйлийн 8 *ter* дугаар заалтад харуулсан Хавсралт C–ийн I бүлгийн хянагдах бодисуудын хэрэглээний суурь түвшний 65 хувийг ашиглах эрхтэй.

(d) Дээр дурдсан (c) дүгээр дэд заалтыг үл харгалзан энэ зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Оролцогч улс нь 2J дугаар зүйлийн хүрээнд өөрийн хэрэглээний суурь түвшинг тооцохдоо 2024, 2025, 2026 онуудаар тооцсон Хавсралт F–ийн хянагдах бодисуудын хэрэглээний тооцсон түвшний дундаж, түүний дээр нэмээд энэ зүйлийн 8 *ter* дугаар заалтад харуулсан Хавсралт C–ийн I бүлгийн хянагдах бодисуудын хэрэглээний суурь түвшний 65 хувийг ашиглах эрхтэй гэж Талууд шийдвэрлэж болно.

(e) Энэ зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж, Хавсралт F–д заасан зохицуулагдах бодисуудыг үйлдвэрлэж буй Оролцогч улс тус бүр нь 2J дугаар зүйлийн хүрээнд өөрийн үйлдвэрлэлийн суурь түвшинг тооцохдоо 2020, 2021, 2022 онуудаар тооцсон Хавсралт F–ийн хянагдах бодисуудын үйлдвэрлэлийн тооцсон түвшний дундаж, түүний дээр нэмээд

энэ зүйлийн 8 *ter* дугаар заалтад харуулсан Хавсралт С–ийн I бүлгийн хянагдах бодисуудын үйлдвэрлэлийн суурь түвшний 65 хувийг ашиглах эрхтэй.

(f) Дээр дурдсан (e) дүгээр дэд заалтыг үл харгалзан энэ зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж, Хавсралт F–д заасан хянагдах бодисуудыг үйлдвэрлэж буй Оролцогч улс нь 2J дугаар зүйлийн хүрээнд өөрийн үйлдвэрлэлийн суурь түвшинг тооцохдоо 2024, 2025, 2026 онуудаар тооцсон Хавсралт F–ийн хянагдах бодисуудын үйлдвэрлэлийн тооцсон түвшний дундаж, түүний дээр нэмээд энэ зүйлийн 8 *ter* дугаар заалтад харуулсан Хавсралт С–ийн I бүлгийн хянагдах бодисуудын үйлдвэрлэлийн суурь түвшний 65 хувийг ашиглах эрхтэй гэж Талууд шийдвэрлэж болно.

(g) Энэ заалтын (a)–аас (f) дүгээр дэд заалтууд нь Оролцогч Талуудын шийдвэрлэсэн шалгуур үзүүлэлтэд суурилсан гадаад орчны температур өндөр байх нөхцөлийн тусгай эрх үйлчлэх нөхцөлөөс бусад үйлдвэрлэл, хэрэглээний тооцсон түвшинд хамаарна.”

6 дугаар зүйл

Протоколын 6 дугаар зүйлийн:

“2A–аас 2I дугаар зүйлүүд”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2A–аас 2J дугаар зүйлүүд”

7 дугаар зүйл, 2, 3, 3 *ter* дугаар заалтууд

Протоколын 7 дугаар зүйлийн 2 дугаар заалтын “– Хавсралт E –ийн, 1991 оны,” гэсэн мөрийн дараа дор томъёолсон мөрийг нэмж оруулна:

“– Хавсралт F–ийн, 2011–2013 онуудын, 5 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй Талуудаас бусад Талууд 2020–2022 онуудын тоо баримтаар хангана, харин 5 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 5 дугаар зүйлийн 8 *qua* дугаар заалтын (d) ба (f) дүгээр дэд заалтуудад хамаарах Талууд 2024–2026 онуудын тоо баримтаар хангана;”

Протоколын 7 дугаар зүйлийн 2, 3 дугаар заалтуудад:

“С ба E”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“С, E, F”

Протоколын 7 дугаар зүйлд 3 *bis* дугаар заалтын дараа дараах заалтыг нэмж оруулна:

“3 *ter*. Протоколын 3 дугаар зүйлийн 1 (d) дүгээр заалтын дагуу Оролцогч улс тус бүр нь Хавсралт F-ийн II бүлгийн зохицуулагдах бодисуудын жилийн ялгарлын статистик тоо баримтыг байгууламж тус бүрээр гарган, Нарийн бичгийн дарга нарын газарт явуулна.”

7 дугаар зүйл, 4 дүгээр заалт

7 дугаар зүйлийн 4 дүгээр заалтын:

“талаарх статистик тоо баримт” ба “талаарх тоо баримтаар хангана” гэсэн үгнүүдийн өмнө:
“үйлдвэрлэлийн” гэсэн үгийг нэмж оруулна.

10 дугаар зүйл, 1 дүгээр заалт

Протоколын 10 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад:

“ба 2I дугаар зүйл”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“, 2I дугаар зүйл ба 2J дугаар зүйл”

Протоколын 10 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын төгсгөлд дараах өгүүлбэрийг нэмж оруулна:

“5 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй аливаа нэг Оролцогч улс нь бусад санхүүгийн механизмаас санхүүжилт олгох сонголт хийж, энэ нь түүний хүлээн зөвшөөрсөн өсөн нэмэгдэх зардлын аль нэг хэсэгт нийцэж байвал, тухайн хэсэг Протоколын 10 дугаар зүйлд заасан санхүүгийн механизмтай нийцэхгүй болно.”

17 дугаар зүйл

Протоколын 17 дугаар зүйлд:

“2A-аас 2I дугаар зүйлүүд”

гэснийг дор дурдсанаар өөрчлөх:

“2A-аас 2J дугаар зүйлүүд”



Хавсралт А

Протоколын Хавсралт А-ийн I бүлгийн хүснэгтийг дараах хүснэгтээр солино:

Бүлэг	Бодис	Озон задлах чадавх*	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадавх (100 жилд)
<i>I бүлэг</i>			
CFCI ₃	(CFC-11)	1.0	4,750
CF ₂ Cl ₂	(CFC-12)	1.0	10,900
C ₂ F ₃ Cl ₃	(CFC-113)	0.8	6,130
C ₂ F ₄ Cl ₂	(CFC-114)	1.0	10,000
C ₂ F ₅ Cl	(CFC-115)	0.6	7,370

Хавсралт С, Хавсралт F

Протоколын Хавсралт С-ийн I бүлгийн хүснэгтийг дараах хүснэгтээр солино:

Бүлэг	Бодис	Изомерийн тоо	Озон задлах чадавх*	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадавх (100 жилд)***
<i>I бүлэг</i>				
CHFCl ₂	(HCFC-21)**	1	0.04	151
CHF ₂ Cl	(HCFC-22)**	1	0.055	1810
CH ₂ FCI	(HCFC-31)	1	0.02	
C ₂ HFCI ₄	(HCFC-121)	2	0.01–0.04	
C ₂ HF ₂ Cl ₃	(HCFC-122)	3	0.02–0.08	
C ₂ HF ₃ Cl ₂	(HCFC-123)	3	0.02–0.06	77
CHCl ₂ CF ₃	(HCFC-123)**	–	0.02	
C ₂ HF ₄ Cl	(HCFC-124)	2	0.02–0.04	609
CHFClCF ₃	(HCFC-124)**	–	0.022	
C ₂ H ₂ FCI ₃	(HCFC-131)	3	0.007–0.05	
C ₂ H ₂ F ₂ Cl ₂	(HCFC-132)	4	0.008–0.05	
C ₂ H ₂ F ₃ Cl	(HCFC-133)	3	0.02–0.06	
C ₂ H ₃ FCI ₂	(HCFC-141)	3	0.005–0.07	



CH_3CFCl_2	(HCFC-141b)**	–	0.11	725
$\text{C}_2\text{H}_3\text{F}_2\text{Cl}$	(HCFC-142)	3	0.008–0.07	
$\text{CH}_3\text{CF}_2\text{Cl}$	(HCFC-142b)**	–	0.065	2310
$\text{C}_2\text{H}_4\text{FCl}$	(HCFC-151)	2	0.003–0.005	
C_3HFC_6	(HCFC-221)	5	0.015–0.07	
$\text{C}_3\text{HF}_2\text{Cl}_5$	(HCFC-222)	9	0.01–0.09	
$\text{C}_3\text{HF}_3\text{Cl}_4$	(HCFC-223)	12	0.01–0.08	
$\text{C}_3\text{HF}_4\text{Cl}_3$	(HCFC-224)	12	0.01–0.09	
$\text{C}_3\text{HF}_5\text{Cl}_2$	(HCFC-225)	9	0.02–0.07	
$\text{CF}_3\text{CF}_2\text{CHCl}_2$	(HCFC-225ca)**	–	0.025	122
$\text{CF}_2\text{ClCF}_2\text{CHClF}$	(HCFC-225cb)**	–	0.033	595
$\text{C}_3\text{HF}_6\text{Cl}$	(HCFC-226)	5	0.02–0.10	
$\text{C}_3\text{H}_2\text{FCl}_5$	(HCFC-231)	9	0.05–0.09	
$\text{C}_3\text{H}_2\text{F}_2\text{Cl}_4$	(HCFC-232)	16	0.008–0.10	
$\text{C}_3\text{H}_2\text{F}_3\text{Cl}_3$	(HCFC-233)	18	0.007–0.23	
$\text{C}_3\text{H}_2\text{F}_4\text{Cl}_2$	(HCFC-234)	16	0.01–0.28	
$\text{C}_3\text{H}_2\text{F}_5\text{Cl}$	(HCFC-235)	9	0.03–0.52	
$\text{C}_3\text{H}_3\text{FCl}_4$	(HCFC-241)	12	0.004–0.09	
$\text{C}_3\text{H}_3\text{F}_2\text{Cl}_3$	(HCFC-242)	18	0.005–0.13	
$\text{C}_3\text{H}_3\text{F}_3\text{Cl}_2$	(HCFC-243)	18	0.007–0.12	
$\text{C}_3\text{H}_3\text{F}_4\text{Cl}$	(HCFC-244)	12	0.009–0.14	
$\text{C}_3\text{H}_4\text{FCl}_3$	(HCFC-251)	12	0.001–0.01	
$\text{C}_3\text{H}_4\text{F}_2\text{Cl}_2$	(HCFC-252)	16	0.005–0.04	
$\text{C}_3\text{H}_4\text{F}_3\text{Cl}$	(HCFC-253)	12	0.003–0.03	
$\text{C}_3\text{H}_5\text{FCl}_2$	(HCFC-261)	9	0.002–0.02	
$\text{C}_3\text{H}_5\text{F}_2\text{Cl}$	(HCFC-262)	9	0.002–0.02	
$\text{C}_3\text{H}_6\text{FCl}$	(HCFC-271)	5	0.001–0.03	

* ОЗЧ-ын утгууд хэлбэлзсэн байдлаар илэрхийлэгдсэн тохиолдолд тухайн ОЗЧ-ыг Протоколын зорилгоор ашиглах үед тухайн хэлбэлзэл дэх хамгийн том үзүүлэлтийг сонгож авна. Дан ганц үзүүлэлтээр харуулсан ОЗЧ-ыг илэрхийлэхдээ лабораторийн хэмжилтэд тулгуурлан тооцож гаргасан болно. Хэлбэлзсэн байдлаар илэрхийлэгдсэн ОЗЧ-ын үзүүлэлтийн



тооцоолол дээр үндэслэн гаргасан бөгөөд тэдгээр нь үндэслэл багатай байна. Тус хэлбэлзсэн үзүүлэлтүүд нь изомерийн бүлэгтэй хамааралтай болно. Тус тооцооллын том үзүүлэлт нь хамгийн өндөр ОЗЧ-тай изомерийн ОЗЧ-ын тооцоолол бөгөөд бага үзүүлэлт нь хамгийн бага ОЗЧ-тай изомерийн ОЗЧ-ын тооцоолол болно.

** Протоколын зорилгоор ашиглахад зориулан худалдаанд хамгийн их тохиолддог бодисуудыг ОЗЧ-ын үзүүлэлтийн хамт илэрхийлэн харуулав.

*** ДДНЧ илэрхийлээгүй бодисуудын хувьд 2 дугаар зүйлийн 9 (а) (ii) дугаар заалтад харуулсан журмын дагуу ДДНЧ-д оруулах хүртэл 0 гэсэн өгөгдмөл үзүүлэлтийг ашиглана.

Дараах хавсралтыг Протоколд Хавсралт E-ийн дараа нэмж оруулна:

“Хавсралт F: Зохицуулагдах бодисууд

Бүлэг	Бодис	Дэлхийн дулааралд нөлөөлөх чадавх (100 жилд)
<i>I бүлэг</i>		
CHF_2CHF_2	HFC-134	1,100
CH_2FCF_3	HFC-134a	1,430
CH_2FCHF_2	HFC-143	353
$\text{CHF}_2\text{CH}_2\text{CF}_3$	HFC-245fa	1,030
$\text{CF}_3\text{CH}_2\text{CF}_2\text{CH}_3$	HFC-365mfc	794
$\text{CF}_3\text{CHFCF}_3$	HFC-227ea	3,220
$\text{CH}_2\text{FCF}_2\text{CF}_3$	HFC-236cb	1,340
$\text{CHF}_2\text{CHFCF}_3$	HFC-236ea	1,370
$\text{CF}_3\text{CH}_2\text{CF}_3$	HFC-236fa	9,810
$\text{CH}_2\text{FCF}_2\text{CHF}_2$	HFC-245ca	693
$\text{CF}_3\text{CHFCHFCF}_2\text{CF}_3$	HFC-43-10mee	1,640
CH_2F_2	HFC-32	675
CHF_2CF_3	HFC-125	3,500
CH_3CF_3	HFC-143a	4,470
CH_3F	HFC-41	92
$\text{CH}_2\text{FCH}_2\text{F}$	HFC-152	53
CH_3CHF_2	HFC-152a	124
<i>II бүлэг</i>		
CHF_3	HFC-23	14,800

II зүйл: 1999 оны нэмэлт, өөрчлөлттэй хамаарах нь

1999 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Бээжин хотноо болсон Талуудын Арван нэгдүгээр хурлаар батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрч өмнө нь, эсвэл одоо нэгэн зэрэг батламж бичиг хадгалуулаагүй бол аливаа улс, эсвэл бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллага тус нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл элсэн орох баримт бичгийг хүргүүлэх эрхгүй.

III зүйл: Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенц, Киотогийн протоколтой хамаарах нь

Тус нэмэлт, өөрчлөлт нь Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь конвенцийн 4 ба 12 дугаар зүйлүүд, Киотогийн протоколын 2, 5, 7, 10 дугаар зүйлүүдэд багтсан хүлээх үүргийн хамрах хүрээнээс гидрофторт нүүрстөрөгчүүдийг хасах зорилго агуулаагүй болно.

IV зүйл: Хүчин төгөлдөр болох

1. Дор дурдсан 2 дугаар заалтын нөхцөлөөс бусад тохиолдолд Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн Протоколын Оролцогч Талууд болох хамгийн багадаа хорин улс, эсхүл бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллагууд тус нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан баримт бичгийг хадгалуулснаар тус нэмэлт, өөрчлөлт 2019 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болно. Тус заасан хугацаанд тухайн нөхцөл биелээгүй тохиолдолд дээр заасан нөхцөл биеллээ олсон өдрөөс хойш 90 дэх өдрөөс тус нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

2. Тус нэмэлт, өөрчлөлтийн I зүйлд заасан Протоколын 4 дүгээр зүйлд оруулсан өөрчлөлт буюу Оролцогч биш улсуудтай хийх худалдаанд тавигдах зохицуулалт нь Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалийн протоколын Талууд болох хамгийн багадаа 70 орон, эсхүл бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллагууд тус нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан баримт бичгийг хадгалуулснаар 2033 оны нэгдүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр болно. Тус заасан хугацаанд тухайн нөхцөл биелээгүй тохиолдолд дээр заасан нөхцөл биеллээ олсон өдрөөс хойш 90 дэх өдрөөс тус нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

3. Энэ зүйлийн 1 ба 2 дугаар заалтуудын зорилтод нийцүүлэн, аль нэг бүс нутгийн эдийн засгийн интеграцын байгууллагын хадгалуулсан тухайн баримт бичгийг тухайн байгууллагын гишүүн орнуудын хадгалуулсан баримт бичиг дээр нэмэлт баримт бичиг болгон тооцохгүй.



4. Энэ зүйлийн 1 ба 2 дугаар заалтуудад заасны дагуу тус нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсны дараа энэ нь тус нэмэлт, өөрчлөлтийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, эсхүл баталсан баримт бичгийг хадгалуулсан өдрөөс хойш 90 дэх өдрөөс Протоколын аливаа бусад Талуудад хүчин төгөлдөр болно.

V зүйл: Түр хугацаанд дагаж мөрдөх

Аливаа Оролцогч улс нь энэхүү нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд 2J дугаар зүйлээр зохицуулагдаж буй аливаа хяналтын арга хэмжээ, 7 дугаар зүйлд заасан холбогдох тайлагнах үүргийг түр хугацаанд хүлээнэ гэдгээ тунхаглаж болно.

----oOo----

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003